

Ж.ЦЭВЭЭН СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Түлхүүр үг: хэв маяг, Ж.Цэвээн, эрдэмтэн, ард албат, элдэв ухаан, ертөнцийн байдал төлөв

Монголд үндэсний сэтгүүл зүй үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ой ирэх онд тохиох гэж байна. 1913 оны 3-р сарын 6-нд Ж.Цэвээн тэргүүтэй Монголын дэвшилт үзэлт сэхээтнүүд «Шинэ толь хэмээх бичиг» гэдэг сонин гаргаж олон нийтэд мэдээлэл түгээх зориудын хэрэгслийн эх суурийг тавьсан нь үнэн хэрэгтээ манай орны мэдээллийн эриний эхлэлийг тавьсан хэрэг байв.

Тэр цагаас хойш Монголын сэтгүүл зүй хэд хэдэн түүхэн хэв маягийг дамжин хөгжихдөө нэг талаар ард түмнийг мэдээллээр хангаж, соён гэгээрүүлэх гэгээн үйлсийг хэрэгжүүлж, нөгөө талаар өөрөө орчин цагийн хөгжингүй сэтгүүл зүйн жишигт хүрч чадсан юм. Ж.Цэвээний үүсгэн байгуулсан Монголын сэтгүүл зүй өнгөрсөн хугацаанд манай ард түмнээс эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олж, Монгол орны олон үеийн хоцрогдлыг эцэс болгон нийгэм, эдийн засаг, улс төрийн гүн гүнзгий өөрчлөлт хийж ирсэн баатарлаг тэмцлийн түүхийг

бичиглэн үлдээжээ. Түүнчлэн манай орны хөгжил дэвшил, бүтээн байгуулалтын их үйлс, ард түмнээс нийгмийн хөгжил хийгээд ертөнцийг үзэх үзэлдээ олсон ахиц дэвшлийг гэрэлт хуудсандаа он дараалан мөнхжүүлж ирсэн юм.

Дэлхий нийтийн хөгжлийн жишгийг даган хүмүүнлэг ардчилсан нийгмийг цогцлуулах их үйлсийн гараан дээр шинэ мянгантай золгосон өнөөгийн түүхэн нөхцөлд Монголын сэтгүүл зүйн хуримтлуулсан туршлага, туулж өнгөрүүлсэн замыг эргэн харж, баяжуулан дүгнэх нь түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Өнөөдөр сэтгүүл зүйн үйл ажиллагаанд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарч, коммунист сэтгүүл зүйгээс чөлөөт ардчилсан сэтгүүл зүйд шилжсэнээр нэг намын үзэл суртлын зэвсэг байсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон ургальч үзлийн индэр болж бие даан ажиллахын зэрэгцээ төр, засгийн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтын үүрэг гүйцэтгэх болсон нь түүхэн боломж мөн. Сэтгүүл зүйн хөгжлийн энэ сонирхолтой цаг үед өнгөрсөн түүх, уламжлалаа эргэн харж, түүний гэрэлтэй, сүүдэртэй талыг нягтлан шинжилж, нэгтгэн дүгнэснээр

ардчилсан нийгмийн чөлөөт сэтгүүл зүйг үр нөлөөтэй эрхлэх өргөн боломж нээгдэх юм. Тийнхүү өнгөрсөн түүхийн ой санамжаа нэмэгдүүлж, олсноо бататгаж, орхисноо нөхөхөд зайлшгүй дурсагдах хүн бол Дорно дахиныг судлагч алдарт эрдэмтэн, XX зууны эхэн үеийн Монголын оюун ухааны эцэг, нэрт соён гэгээрүүлэгч Жамсрангийн Цэвээн мөн.

Ж.Цэвээн 1881 оны 4-р сарын 26-нд Буриадын Агын аймагт төржээ. Бага наснаасаа эрдэм номд дурлаж, 1892 онд Чита хотын гурван жилийн сургуульд орж, улмаар 1897 онд Санкт-Петербургийн гимнази, 1901 онд Эрхүүгийн багш нарын семинарыг тус тус дүүргэж, 1936 онд ЗСБНХУ-ын Шинжлэх Ухааны Академид хэлбичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг амжилттай хамгаалсан байна. Тэрбээр оюутан ахуйгаасаа эхлэн Оросын Газар зүйн Нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбарын номын санд тогтмол сууж, судалгаа шинжилгээний олон арван ном зохиол уншжээ. Түүний зэрэгцээ Буриадын хөдөө тосгоноор явж ардын аман зохиол судалж, цуглуулж эхэлснээр ирээдүйн эрдэмтэн болох замаа тавьжээ.

Ж.Цэвээний эрдэм судлалын бүтээлүүд их сургуулийн оюутан байхад нь олны хүртээл болж эхэлсэн байдаг. Тэрбээр 1905 онд «Өөр угсаатан буриадын өөрийн ба эрхийн ухамсар», 1906 онд «Реформын өмнөх Буриадын эрхийн ухамсар», 1907 онд «Буриад ба чөлөөлөх хөдөлгөөн», «Буриадын народник хөдөлгөөн ба түүнийг шүүмжлэх нь», «Байгалийн чанадад амьдран суугчдын тухай тэмдэглэл» зэрэг буриад угсаатны тухай бичсэн цуврал өгүүллүүдээрээ Оросын Газар зүйн Нийгэмлэгийн хүндэт шагнал болох мөнгөн медаль хүртсэн байна. Мөн

эдгээртэй залгаагаар «Ага Буриадын бөө мөргөлийн ул мөр», «Буриадаар аялсны хураангуй тайлан», «Ага Буриадын онгон», «Өвөр Монголоор 1909-1910 онд аялснаас», «Монголын эдүгээ цагийн пайз» зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлжээ. Түүний эрдэм судлалын ажлыг тухайн үеийн Оросын том эрдэмтэд ихэд үнэлж, хамтран ажиллаж, харилцан санал солилцож, зарим үед зөвлөгөө авдаг байсныг гэрчлэх олон баримт байдаг. С.Ф.Ольденбург, В.В.Бартольд, Л.Я.Штернберг, А.Д.Руднев, Г.И.Рамстедт, Д.А.Клеменц, Р.Ч.Эндрьюс, М.М.Лихтман, Н.К.Рерих, А.П.Карпинский, Б.Я.Владимирцов, Г.Е.Грумм-Гржимайло, П.К.Козлов, В.Л.Котвич, Н.К.Поппе, С.Е.Малов, В.А.Рязановский, Э.Хэниш, Луй Хорш, В.Гурко-Кряжин, А.Боровна, Чорос-Туркин, Домбровский, Б.Уланов, Г.Д.Санжеев, Дүүрэнсан, Эрхэмбат, Хорлоо, Номинханов Цэрэндорж, Очиров, Алтанбаатар нарын зэрэг алдартай эрдэмтэд Цэвээнийг тойрон хүрээлж, нягт хамтран ажиллаж байсан нь шинжлэх ухааны салбарт эзэлж байсан түүний байр суурь, зэрэг зиндааг илэрхийлдэг юм. Тэрбээр Орос, Америк, Герман, Франц, Халимаг, Өвөр Монгол, Буриад зэрэг арав шахам орны эрдэмтэдтэй эрдэм шинжилгээний талаар нягт хамтран ажиллаж байсан өргөн цараатай эрдэмтэн байв.

Ж. Цэвээн Монгол улсын Судар бичгийн Хүрээлэнгийн дүрэм журмыг боловсруулж, үүсгэн байгуулалцсаны дараа эрдэмтэн нарийн бичгийн даргаар нь ажиллаж байв. Амьдралынхаа сүүлчийн жилүүдэд ЗХУ-ын Ленинградын ШУА-ийн Дорно дахины судлалын Институтэд эрдэм шинжилгээний ахлах ажилтны алба хашихын зэрэгцээ

Ленинградын Их Сургуульд багшилж байлаа. Түүний амьдралд тохиолдсон баярт үйл явдлын нэг нь ЗХУ-ын Шинжлэх Ухааны Академийн 260 жилийн ойн хүндэт төлөөлөгчөөр оролцсон явдал байв. Тэрбээр Эрхүү, Ленинградын Их Сургуулиудын профессор бөгөөд хожим нэрт эрдэмтэд болцгоосон Монголын академич Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, мэргэн хэмээх М.Гомбожав, Оросын нэрт эрдэмтэн Л.М.Гумилёв нарыг эрдэм шинжилгээний ажилд дадла-гажуулсан багш нь юм.

1911 онд ялсан Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалыг нийт монгол туургатны дэвшилт сэхээтнүүд халуунаар талархан хүлээн авч, Хайсан, Дамдинсүрэн гэх мэт олон сэхээтэн монгол төр улсын төлөө хүч, мэдлэгээ зориулахаар хүрч ирсний нэг нь Ж.Цэвээн байв. Тэрбээр 1911 онд Монголд ирж Гадаад яамны сургууль соёл эрхэлсэн түшмэл болсон цагаас эхлэн Монгол улсын төрийн тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх, үндэсний соёл боловсролыг хөгжүүлэх үйлсэд нэгэн сэтгэлээр зүтгэж эхэлсэн байна.

Ж.Цэвээн Монгол улсын боловсрол, шинжлэх ухаан, сэтгүүл зүй, хэвлэлийн аж үйлдвэр зэрэг оюуны олон салбарын эх суурийг тавьж, хөгжүүлэн бэхжүүлэхэд гарамгай үүрэг гүйцэтгэсэн олон талтай эрдэмтэн, соён гэгээрүүлэгч байв.

Ж.Цэвээний Монголын оюуны салбарт оруулсан гавьяа үнэхээр их юм. Тэрбээр олноо өргөгдсөн 2 дугаар оны эхээр «...ард албатын мунхаг харанхуйг эрдмийн зул бадруулан гийгүүлсүгэй» гэсэн хүсэл зоригоо илтгэн Гадаад явдлын яамны тэргүүн сайд Чин ван Ханддоржид өргөсөн бичигтээ «Гадаад олон хүчирхэг улсын хамаг чадал нь гагцхүү элдэв ухааны эрдэмд нэвтрэлцэн дээд доод, эр эм ялгалгүй цөм бага наснаас эхлэн

хэрээр адаг, дунд, их гурван сургуульд явж, зүйл бүрийн ухааныг өөр өөрийн төрөлх хэл дээр судалснаар энэ мэт хүчирхэг болжээ... Бүгдээр нийт, тусгай олон тооны эрдэмд нэвтрэлцэхийг ямагт шамдан хичээвээс зохино. Үлгэрийг гадаад улсаас авч, монгол байдалд тааруулж тогтоо-

«

Өнөөдөр сэтгүүл зүйн үйл ажиллагаанд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарч, коммунист сэтгүүл зүйгээс чөлөөт ардчилсан сэтгүүл зүйд шилжсэнээр нэг намын үзэл суртлын зэвсэг байсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон ургальч үзлийн индэр болж бие даан ажиллахын зэрэгцээ төр, засгийн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтын үүрэг гүйцэтгэх болсон нь түүхэн боломж мөн.

»

воос зохимой»¹ хэмээн бичиж байжээ. Тэрбээр бас «Шинжлэх ухааныг эс эрхэмлэвээс улс урагш давшихгүй, бас улсад эрдэмтэн үгүй бол шинжлэх ухаанд мэргэшигсэд гарахгүй. Үүний тул шинжлэх ухааны анги газрыг тусгай байгуулах нь чухал... Шинжлэх ухааны газар нь ганц нэг хүний тусын тулд оршин байх бус. Энэ газар болбаас харьяат улсаар хязгаарлагдахаар үл барам, бүх дэлхий дахинаа тус бүхий ба хүн төрөлхтний боловсролд хувь нэмэр болж, оюун ухааныг нээгдүүлэхэд туслах орон мөн» хэмээн үүсгэн байгуулахаар удаа дараа хөөцөлдөж байсан байгууллагынхаа ач холбогдол,

зорилгыг тодорхойлж байжээ. Түүнчлэн Судар бичгийн хүрээлэн байгуулагдсанд талархаж: «Миний санаачилгаар үүсгэн байгуулагдсан Судар бичгийн хүрээлэн нь... Монгол улсад шинжлэх ухааны зүйлүүдийг ухахад хялбар болгон олны дунд тархаан дэлгэрүүлэх явдлыг залгамжлах болой. Энэ нь мэлэвэргүй хэрэг»² хэмээн бичиж байв. Үнэн хэрэгтээ Ж.Цэвээн бол Монгол улсын шинжлэх ухааны байгууллагыг санаачилж, үүсгэн байгуулахын зэрэгцээ, уг байгууллагын амин сүнс болсон эрдэмтэн нарийн бичгийн даргаар анхны өдрөөс нь эхлэн ажиллаж, эрдэм судлалын үйл хэргийг зүгшрүүлж өгсөн гавьяатан мөн. Гэтэл саяхан болсон Шинжлэх ухааны байгууллагын 90 жилийн ойгоор түүний нэрийг дурсах ч үгүй л өнгөрч байгаа харагдсан.

Ж. Цэвээн Монголын ард түмнийг гэгээрүүлэн боловсруулах ном, сурах бичиг, тогтмол хэвлэлтэй болгохын тулд юуны түрүүнд хэвлэх үйлдвэр чухал гэж үзэн, энэ ажилд өөрийн биеэр идэвхийлэн зүтгэжээ. Тэрбээр Монголын анхны европ маягийн хэвлэх үйлдвэр (одоогийн "Сүхбаатар" хэвлэлийн компани – Л.Н.)-ийн тулгын чулууг тавьсан байна. Үүнийг батлах олон баримт байдаг. Тэр үед Хүрээнд сууж байсан Москвитин гэдэг орос хүн 1912 онд Котвичид илгээсэн захиандаа «хэдэн монголчуудтай элбэн хэвлэх үйлдвэр байгуулж, монгол үсгийг Эрхүүгээс авч, монгол сонин гаргахаар завдаж, монгол түшмэл Эльтеков, Попов, Жамсранов (Ж.Цэвээн – Л.Н.) нартай гэрээ байгуулж байна» гэж бичжээ. Ж.Цэвээн хэвлэх үйлдвэр байгуулах төсөв зардлыг төлөвлөж, тухайн үеийн төрийн таван яамаар нийтдээ 1500 орчим цельков (орос цаасан мөнгө) гаргуулан, түүгээрээ

Оросын Шинжлэх Ухааны Академиас хэвлэлийн машин, цаас, тоног төхөөрөмж авчирч, дармал дарах аргыг ажилчдад өөрөө биечлэн заах, Харбины хэвлэлийн үйлдвэрт дадлагажуулах зэргээр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэсэн байна. Энэ тухай түүний шавь академич Б.Ринчен дурсаж бичсэн бий.

Ж.Цэвээн бас Монгол улсын шинэ цагийн боловсролын байгууллагын эх суурийг тавилцсан зүтгэлтэн мөн. Гадаад яамны сургууль соёл эрхэлсэн түшмэлээр ажиллах хугацаандаа Хүрээний орос сургуульд багшилж, хаант Монголын бага сургуулиудад үзүүлэх 13 нэрийн сурах бичгийг орчуулах, өөрөө зохиох зэргээр бэлтгэж, Монголын охид хөвгүүдийг гадаадын сургуульд суралцуулах талаар эрх мэдэл бүхий хүмүүст нөлөөлж, идэвхийлэн хөөцөлдөж байсан баримт байна. Тэрбээр өөрийн эрхэлж байсан сонинд «Сонсвоос Монгол улсын засгийн газраас энэ зуны цаг сургуулийн монгол хөвгүүдийн зарим нэгийг гадаадад илгээн, зарим нэгийг монгол газар боловсруулан явуулах амой. Тэдний дотроос зургаан хөвгүүнийг ангилиш хэлний багш Ойтикийн хамт Хиагт, Үдэ, Эрхүүгийн зэрэг газар явуулна» хэмээн нийтэлж байсан нь үнэн хэрэгтээ түүний өөрийнх нь хийсэн ажил байсан юм.

Ж.Цэвээн Монголын шинжлэх ухаан, боловсрол, сэтгүүл зүй, хэвлэлийн аж үйлдвэрийн ууган зүтгэлтэн төдийгүй, улс төр, нийгмийн зүтгэлтэн байлаа. Тэрбээр өөрийн эрхэлж байсан «Шинэ толь хэмээх бичиг», «Нийслэл хүрээний сонин» зэрэг тогтмол хэвлэлүүдэд тухайн үеийн Монгол орны дотоод байдал, гадаад харилцаанд баримтлах бодлого чиглэлийн талаар үзэл бодлоо илэрхийлж байсны дээр

хувьсгалт нууц бүлгэм байгуулагдах үеэс эхлэн улс төрийн амьдралд биеэр оролцож, улмаар МАН-ын анхны баримт бичгүүдийг боловсруулахад голлон оролцсон байна. 1921 оны 3-р сарын 1-нд Хиагт хотноо Монголын тэргүүлэх 26 хувьсгалч хуралдаж Ж.Цэвээний боловсруулсан «МАН-аас түмэнд тунхаглан зарлах бичиг»-ийг хэлэлцэн баталж, намыг жинхэнэ ёсоор байгуулахад Ж.Цэвээний мэдлэг боловсрол чухал үүрэгтэй байжээ. Түүнчлэн 1921 оны 5-р сарын 10-21-ний өдрүүдэд болсон МАН-ын Төв Хорооны гишүүдийн өргөтгөсөн хурлаас Коминтерний III их хуралд очих бүрэн эрхт төлөөлөгчөөр оролцсон байна. Товчлоод хэлбэл Ж.Цэвээнийг 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын гол үзэл сурталч байсан гэж үзэх үндэстэй.

Бидний анхаарлыг хамгийн их татах асуудал бол Ж.Цэвээний сэтгүүлчийн үйл ажиллагаа юм. Тэрбээр 1913 оны 3-р сарын 6-нд Монголын ууган тогтмол хэвлэл «Шинэ толь хэмээх бичиг» сониныг эрхлэн гаргаснаар үндэсний сэтгүүл зүйн түүх эхэлсэн билээ. Энэ нь уг чанартаа Монгол оронд мэдээллийн эриний эхлэлийг тавьсан хэрэг байв. Ж.Цэвээний эрхлэн гаргасан «Шинэ толь хэмээх бичиг» сонин анхныхаа дугаараас Монголын сэтгүүл зүйн түүхийг өвөрмөц байдлаар эхлүүлсэн юм. «Түмэн зүйлийг бадруулж, элдэв ухааныг нэвтрүүлмөй» гэсэн уриатай гарсан энэ сонин соён гэгээрүүлэх чиглэлийг тэргүүн эгнээнд тавьж байжээ. Тус сонин анхныхаа дугаарын эхэнд нийтэлсэн «Элдэв ухааныг бадруулсан бичиг» гэсэн сонордуулгад «Эдүгээ олон монголчууд нэгэнт тулгуур төр байгуулан тусгаар улс болсноос хойш зүй нь элдэв эрдэмд боловсорч,

яаравчлан хүчтэй чийрэг болохыг хичээвээс зохих тул манай бичгийн хороо гадаад олон улсын хэрэглэж ахуй зүйл бүрийн эрдмийг товчлон бичиж, дэвтэр байгуулан дармал дарж, олон монголчуудын эрдэм суралцахуй дор нэмэр болгомуй»³ гэж зорилгоо тодорхойлсон байна. Энэ сонордуулгад сонины нийтлэлийн үндсэн сэдвүүд гэж найман зүйл жагсаасныг сийрүүлбэл: «1. Ертөнцийн байдал төлөв, 2. Дэлхий дээрх олон улсын тус тусын байдал, 3. Дэлхий дээрх хүмүүн төрөлхтний балар эрт цагаас янагш улам улмаар аж төрсөн ба ухааны эрдэм боловсорсоор ирсэн түүх, 4. Монгол ба бусад олон улсын түүх, 5. Тооны ба тод шинжлэх ухаан, 6. Элдэв дүрс бодисын шинжлэх ухаан, 7. Элдэв зүйлийн гайхамшигт цадиг түүх, 8. Аж төрөхийг засах ба хүний бие сувилахын зүйл» гэжээ. Үүнээс үзвэл тус сониныхон уншигчдад байгаль, нийгэм, түүх, улс төр, эдийн засгийн ухааны мэдлэг эзэмшүүлж, олон улсын амьдралтай танилцуулах өргөн хүрээтэй нийтлэлийн бодлогыг хэрэгжүүлэхээр зорьж байжээ.

Үүнийг анхныхаа дугаараас эхлэн «Ертөнцийн байдал төлөв», «Тэнгэрийн дуу, цахилгааны учир», «Сав шимийн учир», «Хүний шүтэх шашны учир», «Хүний насны учир», «Дэлхий дээрх хүмүүсийн аж төрөхүйн учир» гэх мэт шинжлэх ухааны мэдээ, тайлбар нийтэлж байсан баримт гэрчилнэ. Ийнхүү «Эрдэм сурахад эрхэмлэх дэвтэр» буюу шинжлэх ухааны суртал нэвтрүүлэг хийх сэтгүүл маягтай гарсан энэ тогтмол хэвлэл тав дахь дугаараасаа сонины хэлбэртэй болж, улс орны нийгэм-улс төрийн амьдралыг тусгаж эхэлсэн ч, хүн ардыг соён гэгээрүүлэх гол шугамаа алдаагүй байдаг. Удаах

дугааруудад «Их Орос улсын учир», «Нар, сарны баригдахын учир», «Англи улсын учир», «Ертөнцийн нөхрүүдийн учир», «Франц улсын учир», «Ертөнцүүдийн анх тогтсон учир», «Герман улсын учир», «Дэлхий», «Сар», «Болгарын тухай», «Япон улсын учир» гэх мэт бүхэлдээ танин мэдэхүйн шинжтэй зүйлүүдийг тасралтгүй нийтэлж байсан нь үүний тод жишээ мөн.

Ж.Цэвээн одоогоос яг 100 жилийн тэртээ Монголын үндэсний сэтгүүл зүйн эх суурийг тавих үйл хэргийг улс төрийн холч хараа, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж байсан нь анхаарал татдаг. Түүний «Шинэ толь хэмээх бичиг», «Нийслэл хүрээний сонин бичиг» чөлөөт ардчилсан хэвлэл байжээ гэж өнөөдөр бид ам бардам ярьж, бичиж байгаа нь эрдэмтэн-сэтгүүлч Ж.Цэвээний амьдарч асан цаг үеэсээ хол түрүүлэн бодож, сэтгэж байсан мэргэн ухааны ач гавьяа юм. Дээрх хоёр сонины нийтлэл өнөөгийн чөлөөт хэвлэлийн шалгуурыг өлхөн давж байгаа нь гайхал төрүүлдэг. Үүнийг тодруулж тайлбарлая. Чөлөөт хэвлэлийн үндсэн шалгуур бол санхүүгийн хувьд бие даасан, төр, засгаас хараат бус, улс төрийн нам, хүчнүүдийн нөлөөнөөс ангид, эрх зүйн орчин бүрдсэн байх явдал мөн. «Шинэ толь хэмээх бичиг» сониныг Богд хаант Монгол улсын засгийн газар санхүүжүүлдэггүй байсан, сонин хаант төрийн мэдлээс ангид, харин ч сөрөг хүчний үүрэг гүйцэтгэж байсан юм. Тэр үед улс төрийн нам, хүчин үүсээгүй, хэвлэл мэдээллийн талаар эрх зүйн ямар нэг зохицуулалтгүй байсан нь чөлөөтэй ажиллах бололцоог бүрдүүлж байсан юм. Хаант Монголын төр, шашны зүтгэлтнүүд «Шинэ толь хэмээх бичиг»-ийн нийтлэлд эгдүүцэн, тус сониныг хаалгах талаар Богд хаанд удаа дараа

санал, шаардлага хүргүүлж байсан нь сонин чөлөөтэй ажиллаж байсны илрэл юм.

Монголын оюуны салбар, түүний дотор сэтгүүл зүйг үүсгэн хөгжүүлэхэд гарамгай үүрэг гүйцэтгэсэн нэрт эрдэмтэн, сэтгүүлч, соён гэгээрүүлэгч Ж.Цэвээнийг хориод оны сүүл үеэс хувьсгалын эсэргүү, Японы тагнуул, барууны үзэлтэн гэх мэтээр хавчин гадуурхаж, Монголд аж төрөх газаргүй болгосон байдаг. Түүнийг гучаад оны сүүл хэрд Санкт-Петербург хотод эрдэм судлалын ажлаа үргэлжлүүлж байхад нь баривчлан шоронд хорьжээ. Тэрбээр хилс хэрэг тулган тамлаж зовоосон шоронгийн гар даалгүй 1942 оны 5-р сарын 14-нд 61 настайдаа Оросын Соль-Елецкийн шоронд нас баржээ⁴.

Тэрхүү хар бараан явдлаас хойш бараг хагас зуун жилийн туршид Цэвээний тухай гэрэл гэгээтэй үг хэлэх хориотой байснаас их эрдэмтэн, сэтгүүлч, соён гэгээрүүлэгчийн гавьяат үйлс улам бүдгэрсээр бараг мартагдах шахсан юм. Харин эрх чөлөөний нар гийсэн 1990 оноос хойш Монголын соёл, боловсролд гүйцэтгэсэн түүний үүргийг эргэн харж ярьж, бичих сайхан завшаан олдсон билээ. Тэр цагаас хойш хорь гаруй жил болсон ч Ж.Цэвээний гавьяат үйлсийг нарийвчлан судалж, нэр төрийг нь эзлэх ёстой байр сууринд нь тавих асуудал бүрэн шийдэгдээгүй байна.

1956 онд Ж.Цэвээнийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээсэн байна. 1961, 1981 онд мэндэлсний нь 80, 100 жилийн ойг тохиолдуулан Буриадад зохиогдсон олон улсын эрдэм шинжилгээний хурлаас түүнийг «Дорно Дахиныг судлагч нэрт эрдэмтэн мөн» гэж дүгнэсэн бол, мэндэлсний нь 130 жилийн ойг угтаж 2010 оны эцсээр Улан-Үд хотод «Ж.Цэвээний эрдэм

судлалын өв: түүх ба орчин үе» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулжээ.

Өнгөрсөн хугацаанд Б.Ринчен, Г.Дэлэг, С.Идшинноров, Г.Жамсранжав, Д.Дашжамц, Ч.Дашдаваа, Ж.Цэцэгмаа, Л.Норовсүрэн, Ц.Хасбаатар, Т.Баасансүрэн, Л.Бат-Очир, Ч.Нарантуяа, Г.Цэрэндорж, Д.Даш, Д.Ёндон, Н.Ариунзаяа, Л.Лувсанчүлтэм, С.Түвшин, М.Бадамням, Б.Шагдаржав, Б.Пунсалдулам, Б.Нямдорж, Ч.Зоригт, Н.Дариймаа нарын зэрэг эрдэмтэн, судлаач, нийтлэлчид Ж.Цэвээний амьдрал тэмцэл хийгээд Монголын улс төр, шинжлэх ухаан, боловсрол, сэтгүүл зүйн салбарт оруулсан хувь нэмрийг янз бүрийн түвшинд судалсан байна. Түүнээс гадна Г.Н.Заятуев, Д.Б.Улымжиев, Р.Пубаев, Ц.П.Ванчикова, З.Г.Фосдик нарын зэрэг гадаадын судлаачид ч үгээ хэлцгээжээ.

Эдгээр хүмүүсийн бичиж нийтлүүлсэн зүйлийг Ж.Цэвээний амьдрал тэмцэл, эрдэм шинжилгээ, соён гэгээрүүлэх олон талт үйл хэргийг эрж сурвалжлан, эмхтгэж цуглуулан бүтээсэн ном товхимол, эрдмийн зэрэг горилж бичсэн шинжлэх ухааны нэг сэдэвт зохиол, судалгаа шинжилгээ, сурталчилгааны өгүүлүүд, Ж.Цэвээний бүтээлүүдийн тухай шүүмж судлал гэсэн дөрвөн хэсэгт ангилан үзэж болохоор юм. Ж.Цэвээн судлалд жинтэй хувь нэмэр оруулсан хүний нэг нь түүхч С.Идшинноров мөн. Тэрбээр Ж.Цэвээний эрдэм шинжилгээ, нийтлэлийн бүтээлүүд болон гадаад, дотоодын улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдтэй харилцаж байсан захидал, бичгүүдийг сурвалжлан цуглуулж 1997, 2000 онд «Түүвэр зохиолууд»-ынх нь эмхтгэлийг хоёр дэвтрээр хэвлүүлсэн билээ. Уг эмхтгэлийг их эрдэмтний намтар түүхийг тодруулж, бүтээл

туурвилд нь үнэлэлт дүгнэлт хийсэн судалгааны өмнөх үгтэйгээр хэвлүүлсэн юм. Түүнчлэн Ж.Цэвээний эрдэм судлал, нийтлэлийн бүтээлүүдийн ном зүйн лавлахыг хавсаргаж өгсөн нь энэ эрхэм хүний амьдрал үйлс, бүтээл туурвилыг сонирхон судлагчдад суурь хэрэглэгдэхүүн болсон билээ.

Ж.Цэвээн судлалд шинэ хуудас нээсэн өөр нэг бүтээл нь судлаач Ч.Нарантуяагийн эмхтгэсэн «Их соён гэгээрүүлэгч Жамсраны Цэвээн» (2011) гэдэг ном мөн. Энэ номд Ж.Цэвээний намтар, эрдэм шинжилгээ, нийтлэлийн бүтээлүүдийн талаар Монгол болон бусад улсын эрдэмтэн судлаачдын урьд өмнө мэдэгдээгүй байсан шинэ сонин баримт, мэдээлэл агуулсан өгүүлэл, тэмдэглэлүүдийг сурвалжлан оруулсан байна.

Ийм бүтээлийн тоонд Ц.П.Ванчиков, Д.Энхтөр нарын бичсэн «Материалы Ц.Жамцарано в Государственной публичной библиотеке МНР», Андрей Рудневийн «Өргөөгийн ард иргэдийн төлөө амиа өргөсөн буриад бүсгүй Долгор буюу Варвара», Б.Ринченгийн «Цэвээний гэсэрийн оршил», Н.Хишигтийн «Участие Ц.Жамцарано в Монгольской революции 1921 г.», З.Лонжидын «"Монгол газар бошгыг халах явдлын тулгар болгосны товч түүх" бичгийн тухай», Ч.Нарантуяагийн «Ж.Цэвээний талаар Монголд судлагдсан нь» гэх зэрэг шинэлэг мэдээлэл агуулсан өгүүлэл, материал олон байна. Ц.П.Ванчикова, Д.Энхтөр нар өгүүлэлдээ Монгол улсын Төв номын сан болон архивт байгаа Ж.Цэвээний холбогдолтой баримт материалуудыг их эрдэмтний хувийн харилцааны бичиг баримтууд, эрдэм шинжилгээний холбогдолтой баримт материалын хувийн сан бүрдүүлэх зорилгоор цуглуулсан материалууд

гэсэн хоёр хэсэгт ангилж мэдээлсэн байна. Эхний хэсэгт, тухайлбал 1919 онд Ж.Цэвээн Буриадын багш нарын холбооны жуух бичгээр шагнагдсан тухай баримтыг мэдээлжээ. Уг жуух бичигт Буриадын үндэсний хөдөлгөөнийг хөгжүүлэх хийгээд Буриадын ард түмний хувь заяаны төлөө хийсэн түүний гавьяа зүтгэлийг өндөр үнэлсэн байна. Баримт материалуудын хоёр дахь хэсэгт голдуу Монгол улсын Засгийн газраас Хаант Оросын засгийн газар болон Элчин консулын түвшинд харилцсан бичиг, захидал, гэрээ хэлэлцээрүүдийн хуулбарууд байгааг тэмдэглэжээ. Ж.Цэвээний хувийн амьдрал болон улс төр, шинжлэх ухаан, боловсрол, сэтгүүл зүй, хэвлэлийн салбарт өрнүүлж байсан олон талт үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан судалгаа хийхэд эдгээр материал чухал хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм.

А.Рудневийн 1914 онд бичиж, «Живая старина» гэдэг эмхтгэлд хэвлүүлсэн «Өргөөгийн ард иргэдийн төлөө амиа өргөсөн буриад бүсгүй Долгор буюу Варвара Владимировна Ванпилова» гэдэг төсөрхөн өгүүлэл Ж.Цэвээний хувийн амьдралд холбогдож байна. Монгол нэр нь Вандангийн Долгор гэгч тэр эмэгтэй ардын дууны цуглуулга хийж, өөрөө сайхан дуулдаг, Буриадын ардын эмнэлгийг сонирхон судлагч нэгэн байжээ. Петроградын Лескафтын дээд курс, Бүх Оросын эх барих-эмэгтэйчүүдийн их сургуулийг зэрэг дүүргэсэн тэр эмч бүсгүй Өргөөнд дэгдсэн эсэргэнэт хижиг өвчинтэй тэмцэж олон хүний амь аварч яваад өөрөө халдвар авч нас барсан эрэлхэг эмэгтэй юм. А.Руднев өгүүлэлдээ Долгор их сургуулиа төгсөж очоод Цүүгэл нутагт нэг жил ажиллах зуур Ж.Цэвээний эхнэр болсон тухай өгүүлсэн нь сонирхол татаж байна.

Үүнээс үүдэн тэр бүсгүй Цэвээнтэй хэдий болтол амьдарсан, 1914 онд нас бартлаа Цэвээнтэй хамт байсан уу, Цэвээн бидний сайн мэдэх С.Бадамжавтай хэзээ гэрлэсэн бэ? гэх мэт хувийн амьдралтай нь холбоотой олон асуудал урган гарч байгаа юм.

Ж.Цэвээний 1926 онд бичиж 3000 хувь хэвлэн тараасан «Монгол газар бошгыг халах явдлын тулгар босгосны товч түүх» гэдэг товхимлын жинхэнэ эх өнөөдөр эрээд олдохгүй болжээ. Зөвхөн Улсын Төв номын сангийн фондын эрхлэгч байсан Н.Молом гэдэг хүний монгол бичгээр бичиж авсан хуулбар л ганц хувь үлдсэн юм. Харин түүхч З.Лонжид «Уулын өвгөн» гэдэг нууц нэрээр нийтэлсэн тэр бүтээлийг кирилл бичигт буулган өмнөх товч үг хадан нийтлүүлжээ. Сонины нэг өгүүллийн хэмжээтэй тэр товхимол үндэсний ардчилсан хувьсгалын үүсэл, Ж.Цэвээний улс төрийн үзэл бодол, байр суурийг нарийвчлан судлахад төдийгүй, бүтээл туурвилыг нь эмхлэн цэгцлэхэд тус болох юм.

Монголын Сэтгүүлчдийн Эвлэлийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Т.Баасансүрэнгийн санаачилгаар Монголд үндэсний сэтгүүл зүй үүсч, хөгжсөний 100 жилийн ойг угтаж «Монголын шилдэг нийтлэл» цувралыг гаргаж байгаа билээ. Уг цувралын эхний ботийг эрдэмтэн-сэтгүүлч Ж.Цэвээний нийтлэлийн бүтээлээр гаргах ажлыг энэхүү өгүүллийг бичигч миний бие Т.Баасансүрэнтэй хамтран гүйцэтгэсэн бөгөөд уг ажлын онцлог нь Ж.Цэвээний үйл хэргийн нэг чухал чиглэл болсон сэтгүүл зүйг үүсгэн хөгжүүлэх тэмцлийн түүхийг тодруулж, нийтлэлийн бүтээлүүдийг нь эмхлэн цэгцэлсэнд оршино. Ж.Цэвээн судлалд цучил нэмсэн бас нэг ажил бол Ж.Цэвээний мэндэлсний

130, Монголын сэтгүүлчдийн байгууллагын 60, МОНЦАМЭ агентлагийн 90 жилийн ойд зориулж зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын материал мөн. Тус эмхтгэлд сэтгүүл зүй судлаач Т.Баасансүрэн, түүхч Ч.Дашдаваа, Цэвээнийг судлагч Ж.Цэцэгмаа нарын илтгэл, бусад хүмүүсийн хэлсэн үг нийтлэгдсэний дотор Ж.Цэвээний амьдрал, бүтээлийн тухай шинэ, сонирхолтой мэдээ багтсан байна.

Ж.Цэвээний сэтгүүлчийн үйл ажиллагааг судлахад үнэтэй хувь нэмэр оруулсан бүтээлийн нэг бол сэтгүүл зүй судлаач, доктор (Ph.D) Т.Баасансүрэнгийн «XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл» гэдэг нэг сэдэвт бүтээл юм. Уг бүтээлд Монголд үндэсний сэтгүүл зүйн түүхийг эхлүүлсэн «Шинэ толь хэмээх бичиг», «Нийслэл хүрээний сонин бичиг» сонинуудын нийтлэлийг шинжлэх явцдаа нэр бүхий хоёр сонин монголоо гэсэн сэтгэлтэй, үндэсний эрх чөлөөний төлөө тууштай тэмцэгч сэхээтнүүдийг нэгтгэж байсны тэргүүн манлайд нь Ж.Цэвээн, Д.Бодоо нар явж байсныг тэмдэглээд «Ж.Цэвээн тэргүүтэй Монголын сэтгүүлчид XX зууны Монголын нийгмийн оюун санааны охь дээжийг "Шинэ толь хэмээх бичиг" сониныхоо гал тогоонд хандлан дээжилж, түмэн олон монголчуудынхаа сонорыг мялааж, нүдийг нээж, хүн ардын ухааныг ундруулж, уралдуулж

«
Өнөөдөр тулгамдаж байгаа асуудал бол XX зууны монголчуудын оюун ухааны эцэг болсон энэ нэрт эрдэмтэн, их соён гэгээрүүлэгчийн бүтээл туурвилын бүрэн чуулганыг бүтээх явдал мөн билээ. Тэрбээр Монголын үндэсний эрх чөлөөг бадруулах, тусгаар тогтнолыг хамгаалж бэхжүүлэх, улмаар хувьсгалт тэмцэл өрнүүлж улс орныг дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн хөгжүүлэх үйл хэрэгт мэдлэг ухаанаа дайчилж, өөрийн биеэр үлгэрлэн оролцсон томоохон зүтгэлтэн юм.
»

эхэлжээ»⁵ гэж манай улсын ууган тогтмол хэвлэл, түүнийг эрхлэн гаргагч Ж.Цэвээний гавьяат үйлсийг өндөр үнэлсэн байна.

Ж.Цэвээний Монголын шинжлэх ухаан, боловсрол, сэтгүүл хөгжилд оруулсан гавьяат үйлсийг эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээлийн түвшинд судалж, эрдмийн зэрэг хамгаалж эхэлсэн нь ерээд оноос эхтэй байна. Өнгөрсөн хугацаанд судлаач Ж.Цэцэгмаа их эрдэмтэн Ж.Цэвээний улс төр, нийгэм, шинжлэх ухаан, боловсролын салбарт гүйцэтгэсэн үүргийг судалж доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан бол, энэ өгүүллийн зохиогч 1996 онд МУИС-ийн эрдэм шинжилгээний бичигт нийтлүүлсэн өгүүлэлдээ «Ж.Цэвээн бол Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн»⁶ гэсэн дүгнэлтийг анх түрүүнд хийж, 2004 онд «Монголын сэтгүүл зүйн эх суурийг 1913 онд гарсан "Шинэ толь хэмээх бичиг" сонин тавьсан», «Монголын сэтгүүл зүйг үндэслэгч нь Ж.Цэвээн мөн»⁷ гэсэн үндсэн хоёр дүгнэлтийг шинжлэх ухааны докторын диссертацидаа дахин дэвшүүлж, эрдэмтэн судлаачдаар хүлээн зөвшөөрүүлсэн билээ.

Ж.Цэвээний улс төр, шинжлэх ухаан, нийтлэлийн бүтээлүүдийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлага байсаар байгаа бөгөөд урьд өмнө мэдэгдэж байгаагүй шинэ шинэ мэдээ

баримт, бүтээл туурвил гарч ирсээр байгаа нь үүний баталгаа юм. Саяхан сэтгүүл зүй судлаач, доктор (Ph.D) Т.Баасансүрэн Ордос нутагт байдаг чингисийн онгоныг тахиx ёслолд оролцож 1910 онд Ж.Цэвээний бичсэн «Цагаан сүргийн их тайлга» гэдэг тэмдэглэлийг Өвөр Монголоос олж нийтлүүлсэн байна. Мөн залуу судлаач доктор (Ph.D) Н.Ариунзаяа «"Шинэ толь хэмээх бичиг" сонины зарим нийтлэлийн зохиогчийг тодруулах асуудалд», «Эрдэмтэн-сэтгүүлч Ж.Цэвээний нэгэн бүтээлийн тухай» гэх зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж, «Шинэ толь хэмээх бичиг»-т байгаа зохиогч нь мэдэгдэхгүй байсан зарим нийтлэлийг Ж.Цэвээнийх гэж баталсан төдийгүй, «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» гэдэг шинжлэх ухааны хялбаршуулсан зохиолыг нь тухайн үед Монгол улсын «Шинэ толь хэмээх бичиг», Өвөр Монголын «Мүгдэнгийн монгол сэтгүүл» зэрэг тогтмол хэвлэлүүдэд хэсэглэн нийтэлж байсныг олж илрүүлсэн нь Ж.Цэвээний уран бүтээлийн өвийг баяжуулахад тустай зүйл болсон байна.

Ж.Цэвээний үйл амьдрал, бүтээл туурвилын талаар дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын бичиж нийтлүүлсэн зүйл цөөн бус байна. Бидэнд лавтай мэдэгдэж байгаа бүрэн бус тооцоогоор түүний тухай дагнасан буюу дэлгэрэнгүй дурдсан бие даасан ном, зохиолын тоо 30 шахам, архивийн баримт материал 100 гаруй нэгж, эрдэм шинжилгээ, сурталчилгааны өгүүлэл, дурдатгал, тэмдэглэл 80 орчим, өөрийнх нь бичиж хэвлүүлсэн ном зохиол, эрдэм судлалын өгүүлэл, захидал, цуглуулга хэдэн зуугаар тоологдож байна. Ялангуяа түүнтэй хамтран ажиллаж байсан гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээлд тэмдэг-

лэж үлдээсэн зүйл арвин бий. Тэр бүхнийг эрж сурвалжилж, олж цуглуулахад их хүч хөдөлмөр орох нь мэдээж юм. Бид зөвхөн зах зухаас нь л мэдэж байна. Нөгөө талаар Ж.Цэвээний судалгаа шинжилгээний бүтээлийн талаар гадаадын эрдэмтдийн өгсөн үнэлэлт дүгнэлт, шүүмж судлалын бүтээлүүд ч цөөнгүй гарчээ. Тэдгээрийг судалж сурвалжлан, нэгтгэн дүгнэх нь эрдэмтний хувьд Ж.Цэвээн чухам хэн байж вэ, хэр зэрэг үнэ цэнтэй юм хийсэн хүн бэ? гэдгийг нарийвчлан тогтоох төдийгүй, олон улсын Монголыг судлагч эрдэмтдийн дундах түүний эрэмбэ, байр суурийг тодруулахад тустай юм.

Ө нөөдөр тулгамдаж байгаа асуудал бол ХХ зууны монголчуудын оюун ухааны эцэг болсон энэ нэрт эрдэмтэн, их соён гэгээрүүлэгчийн бүтээл туурвилын бүрэн чуулганыг бүтээх явдал мөн билээ. Тэрбээр Монголын үндэсний эрх чөлөөг бадруулах, тусгаар тогтнолыг хамгаалж бэхжүүлэх, улмаар хувьсгалт тэмцэл өрнүүлж улс орныг дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн хөгжүүлэх үйл хэрэгт мэдлэг ухаанаа дайчилж, өөрийн биеэр үлгэрлэн оролцож байсан томоохон зүтгэлтэн юм. Түүнчлэн Монголын улс төр, шинжлэх ухаан, боловсрол, сэтгүүл зүй, хэвлэлийн салбарын үндэс суурийг тавилцаж, бүтээл туурвилаараа үлгэрлэж явсан гарамгай соён гэгээрүүлэгч мөн. Энэ бүх гавьяат үйлсийг нь бодитой үнэлж, зохих байранд нь тавих цаг нэгэнт болсон байна. Сүүлийн жилүүдэд «Их засаг» их сургуулийн номын санг түүний нэрэмжит болгож, Монголын сэтгүүлчдэд олгодог Ж.Цэвээний нэрэмжит уран бүтээлийн дээд шагнал буй болгосон зэрэг нь дэмжиж хэвшүүлүүштэй эхлэл болсон юм.

Ялангуяа сэтгүүлчдэд олгодог Ж.Цэвээний нэрэмжит шагналыг зохиолчдод олгодог Д.Нацагдоржийн нэрэмжит шагналтай эн зэрэгцэх хэмжээнд тавьж, Монгол улсын Засгийн газрын шагнал болгон нэр хүндийг нь өсгөх хэрэгтэй санагдана.

Үүнтэй холбоотойгоор одоогоор сэтгүүлчдэд олгодог олон нэрэмжит шагналыг цөөлөх буюу эрэмбэлэх ажил зохиож, тэдгээрийн манлайд Ж.Цэвээний нэрэмжит шагналыг тавих нь зүйтэй. Эцэст нь Монголд үндэсний сэтгүүл зүй үүсч, хөгжсөний 100 жилийн тэгш ойг тохиолдуулан Ж.Цэвээний хөшөөг улсын нийслэлд босгож мөнхжүүлэх үйл хэргийг Монголын сэтгүүлчдийн эвлэл санаачилж, шинжлэх ухаан, боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэмжлэг туслалцааг авч, зориудын сан байгуулан, цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Ишлэл

¹ Норовсүрэн Л. 2011. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн дэвтэр. УБ., 149 дэх тал.

² Цэвээн Ж. 1997. Түүвэр зохиолууд. I эмхтгэл. УБ., 15 дахь тал.

³ «Шинэ толь хэмээх бичиг». 1913. №1.

⁴ 1993. Цагаан ном. Улс төрийн хэлмэгдэгсдийн судалгааны төв. I боть. УБ., 32 дахь тал.

⁵ Баасансүрэн Т. 2009. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ., 27 дахь тал.

⁶ Норовсүрэн Л. 1996. Ж.Цэвээн бол Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн. МУИС-ийн ЭШБ. №2 (115)

⁷ Норовсүрэн Л. 2004. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд. Хэлбичгийн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 16, 22 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ариунзаяа Н. 2010. «Шинэ толь хэмээх бичиг» сонины зарим нийтлэлийн зохиогчийг тодруулах асуудалд. «Сэтгүүл зүй» МУИС-ийн ЭШБ. № 11(337).

2. Ариунзаяа Н. 2011. Эрдэмтэн сэтгүүлч Ж.Цэвээний нэгэн бүтээлийн тухай. «Сэтгүүл зүй» МУИС-ийн ЭШБ. №12 (370).

3. Баасансүрэн Т. 2009. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ.

4. 2011. Их соён гэгээрүүлэгч Жамсраны Цэвээн (1880-1942). (Эмх. Ч.Нарантуяа). УБ.

5. Норовсүрэн Л. 1996. Ж.Цэвээн бол Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн. МУИС-ийн ЭШБ. №2 (115).

6. Норовсүрэн Л. 2004. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд. Хэлбичгийн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ.

7. Норовсүрэн Л. 2011. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

8. Норовсүрэн Л. 2012. XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ.

9. 1993. Цагаан ном. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн судалгааны төв. I боть. УБ.

10. Цэвээн Ж. 1997. Түүвэр зохиолууд. I эмхтгэл. УБ.

11. Цэвээн Ж. 2000. Түүвэр зохиолууд. II эмхтгэл. УБ.

12. Цэцэгмаа Ж. Ц.Жамцарано – основатель образовательных учреждений в Монголии // Мир Центральной Азии. Материалы междунар. науч. конф. Улан-Удэ, 2002. Т. II. История. Социология.

Abstract

In this story, ideas focused on to study and explore more in depth of Mongolian journalism founder and enlightener Tseveen J. was proposed. In relation of 100th years anniversary of Mongolian national journalism, concerning proposals of publishing complete collections based on the overview of Tseveen's knowledge studies and publications, truly appreciating his contributions to journalism and therefore, erecting a monument of him in the capital city were forwarded.